

САРЫН МЭДЭЭ

2017 оны 09 дүгээр сард болсон онцлох үйл явдлуудаас...

ӨРМӨН ШАРГАЛ ГОВЬ-2017 ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА БОЛЛОО

Сумын нийгэм эдийн засгийн үндсэн чиглэл тусгагдсаны дагуу жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Өрмөн шаргал говь-2017” үзэсгэлэн худалдаа энэ жил 9 дэх жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. Энэ удаагийн үзэсгэлэн худалдаа гар урлал, цагаан идээ, хүнсний ногоо гэсэн төрлөөр явагдаж 18 жижиг дунд үйлдвэрлэгч 2-38 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож шилдгүүдээ шалгарууллаа. Цагаан идээний төрлөөр:

1-р байр Д.Сувдаа /Баянгол/

2-р байр С.Алтантуяа /Хамтын хүч баг/

3-р байр Т.Цогзолмаа /Сондуулт баг/

Хүнсний ногооны төрлөөр:

1-р байр Д.Цогт-Очир /Баянгол/

2-р байр Д.Бямбатөгс /Баянгол/

3-р байр Б.Бадмаабанзрагч /Баянгол баг/

Гар урлалын төрлөөр:

1-р байр Сумын ахмадын “Шаргын говь” нөхөрлөл

2-р байр Д.Ганбаатар /Баянгол баг/



АХМАДЫН “ЭГШИГЛЭНТ АЯЛГУУ “ УРЛАГИЙН ТОГЛОЛТ БОЛЛОО

Олон Улсын ахмадын өдрийг угтан сумын ахмадын холбооноос санаачлан ахмадын урлагийн тоглолтыг зоион байгууллаа. Тоглолтод МУСТА С.Цолмон болон ардын авъяастан 20 гаруй ахмад азай буурлууд оролцлоо.



“АХМАД БУУРЛУУДДАА ТУСАЛЪЯ” ХӨДӨЛГӨӨН ӨРНҮҮЛЛЭЭ

Олон Улсын ахмадын баярыг угтан сумын Залуучуудын холбооноос санаачлан “ахмад буурлууддаа тусалъя” уриан дор 5 ахмадад аргал түлш бэлтгэж өгөх ажлыг хийлээ. Уг арга хэмжээнд 12 жилийн ахлах ангийн 15 сурагч, 6 залуу оролцож 2 бонго буюу 30 шуудай аргалыг түүж бэлтгэсэн байна.



Боловсролын чиглэлээр:

2017 оны 9 сарын 1-ний өдөр хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагааг эхлүүлэн, багш, сурган хүмүүжүүлэгч, ажилтан албан хаагч, эцэг эх, суралцагчдыг хамруулан өргөн дэлгэр зохион байгууллаа. Нээлтийг сургуулийн захирал М.Золбаяр эхлүүлэн, сумын засаг дарга М.Тунгалагтамир оролцон, Монгол улсын баатар М.Жанчивын нэрэмжит шагналыг 5а ангийн сурагч С.Сүхбатад гардуулан өглөө.



Хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаанд эцэг эхийн төлөөлөл Н.Жанцан үг хэлж, эцэг эх, суралцагч, багш хамтран ажиллахыг хүслээ. Мөн авьяаслаг хүүхэд багачууд дуулж, бүжиглэн баярыг үйл ажиллагааг чимллээ.



Нээлтийн үйл ажиллагаанд зориулан дааган насны морьдын уралдаан зохион байгуулан, 1-р байрыг улсын алдарт тариаланч Д.Бямбатөгс ивээн тэтгэн, хүүхэд багачуудад ургацынхаа дээжнээс өглөө. Дааган насны морьдын уралдаанд:

1-р байрт: Б.Баасандоржийн хүрэн

2-р байрт: Б.Ганхөлөгийн алаг

3-р байрт: Г.Билгүүнболдын халтар

4-р байрт: Г.Сэлэмхааны халтар

5-р байр Х.Төгсбатын хүрэн тус тус байр эзэллээ.



Хүүхдийн үндэсний бөхийн барилдааныг 1-5-р анги, 6-9-р анги, 10-12-р анги гэсэн ангилалаар зохион байгууллаа.

№	Байр	1-5-р анги	6-9-р анги	10-12-р анги
1.	Түрүү	А.Сүхбат 5а	Г.Алтаншагай 9а	Б.Дашдаваа 10а
2.	Үзүүр	Б.Лхагвадорж 4а	Б.Дагвадорж 9а	Т.Ойдовгарав 12а
3.	Шөвгөрсөн	Г.Тэмүүлэн 4а	Д.Дамдинбазар 9а	Л.Гүндсамбуу 12а
4.	Шөвгөрсөн	О.Жигүүржил 3а	Г.Бүрэнбаатар 8а	Ц.Хишиг-Эрдэнэ 12а



Хичээлийн шинэ жилийн нээлтэд шинээр элсэн суралцах сурагчиддаа хүлээн авч, 1-р цагийг “Эх хэлээ дээдэлъе” сэдвийн хүрээнд, 2-р цагийг төрийн соёрхолт, их зохиолч Ч.Лодойдамбын намтар уран бүтээлээс анги удирдсан багш нар орлоо.



2017-2018 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагааг хөтөлбөр төлөвлөгөөний дагуу амжилттай зохион байгууллаа.

Соёлын чиглэлээр:

МУ-ын урлагийн гавъяат зүтгэлтэн Даваасүрэнгийн Баярбаатарын цолны мялаалга баяр наадам өргөн дэлгэр боллоо.



Энэ сард ОНСТ-аар 24 хүүхэд 18 насанд хүрэгч нийт 42 хүн үйлчлүүлсэн байна. Ахмадын баярыг угтаж сумын ахмадуудын хамтарсан тоглолтыг бэлтгэн 2017.09.27-нд сумын иргэд хөдөлмөрчдөд тоглож хүргэлээ. ОНСТ-ын ажилтан аймгийн төвд сургалтанд хамрагдаад ирсэн. Өрмөн шаргал говь-2017 үзэсгэлэнгийн баярыг засаж бэлтгэсэн.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Өсвөр насны 20 гаруй охидод Бэлгийн замаар дажих халдвар, сарын тэмдэгийн мөчлөгийн талаар мөн өсвөр насныханд тарваган тахал өвчний талаар 4 багийн 150 гаруй иргэдэд сурталчилгааны материал тараалаа. Мөн Говь-Алтай аймгийн нарийн мэргэжлийн эмч нарийг захиалга өгч сумын нийт 184 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулаж Канад улсын нүдний нарийн мэргэжлийн эмч нар ирж иргэдэд үзлэг хийж харааны шил тааруулаж нийт 78 иргэнийг хамруулсан байна.

18-49 насны 150 иргэдээс БЗДХ,ДОХ,Тэмбүү, В,С вирус Хелокобагтер зэрэг шинжилгээг авсан байна. Цэцэрлэг, сургуулийн нийт 46 хүүхдэд шүдний үзлэгт хамрагдсан байна. Багаар явж тахалын вакцинд 146 иргэнийг хамруулж сурталчилгааны материал тараалаа. Эрүүл монгол хөтөлбөрийн хүрээнд элэгний В,С вирусын шинжилгээг сондуулт багаар явж хийлээ.

Мэдээ бэлтгэсэн: Д.Ончимэг